



## БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/1/СТА-ТТЗ

Баянхонгор  
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат  
Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn  
Аудитын менежер: Д.Цэцэгмаа  
Утас: 88089024      Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn  
Аудитор:              Б.Азбаяр  
Утас: 99061429      Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1.	Оршил .....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....	9
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар .....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .	10
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: .....	11
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13

---

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.03.25 № 9/166  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2519318

E:\ajil\2019 on\STA 2018\20. Gurwanbulag ZD\4.Tailagnal\Гурванбулаг ТЭЗ гэрчилгээ.docx

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### **Үүрэг хариуцлага**

Гурванбулаг сумын Засаг дарга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## **2 Аудитын тайлан**

---

### **2.1. Оршил**

Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга Ц.Энхболдод танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 15-наас 2019 оны 03 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дугаар сарын 08-нд №06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Гурванбулаг сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Гурванбулаг сумын Засаг дарга нь “Төрийн үйлчилгээний орчинг сайжруулж, чадварлаг багаар чанартай үйлчилгээг хүргэж, боловсролтой, эрүүл, хүмүүнлэг, орлоготой иргэнийг төлөвшүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Гурванбулаг сумын Засаг даргын үйл ажиллагааны зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, иргэдэд хүнд сурталгүй аливаа чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчлэх явдлыг хэвшүүлж, эдийн засаг нийгмийн хөтөлбөртэй уялдуулсан цэгцтэй, уян хатан бөгөөд үр ашигтай үйлчилгээг бий болгоно.

Гурванбулаг сумын Засаг даргын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 8 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 5 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Гурванбулаг сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	3	3	-	2	-
	Дүн	3	3	-	2	-

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Гурванбулаг сумын Засаг даргын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гурванбулаг сумын Засаг даргын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа бүртгэл мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Гурванбулаг сумын Засаг даргын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан" программ хангамж ашигладаг байна.

Гурванбулаг сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Гурванбулаг сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийжээ. Аудитаар нийт Гурванбулаг сумын ИТХ, ЗДТГ, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв нь 2018 оны тайланг хугацаандаа илгээсэн байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Гурванбулаг сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1909146,7 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 19091,5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Гурванбулаг сумын Засаг даргын болон төвлөрүүлэн захирагчын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 88846,6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангилалаар үзүүлэв. Үүнд:

### **2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар**

**Асуудал 1:** Дахин үнэлгээгээр 5 нэрийн барилга байгууламжийг 16799,5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, газрыг 11926,0 мянган төгрөгөөр тус тус үнэлж, үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгажээ. Жилийн эцсийн тайланд ҮХ-ийн элэгдлийн тооцооллыг 37119,9 мянган төгрөгөөр дутуу тусгасан.

**Шийдэл:** Санхүүгийн тайланд зарцуулсан.

**Асуудал 2:** Цалин,НДШ тулган шалгахад 969,8 мянган төгрөгийг ажиллагсадаас илүү суутган авсныг өглөгөөр бүртгээгүй зөрчил илэрлээ.

**Шийдэл:** Санхүүгийн тайланд зарцуулсан.

**Асуудал 3:** БМ, ҮХ-г орлого, зарлагын журнал тооллогын бүртгэлтэй тулган шалгахад малыг нас дэвшүүлж орлогоор бүртгээгүй 14970.0 мянган төгрөг.

**Шийдэл:** Зөвлөмж өгсөн.

**Асуудал 4:** СХС-аас зээл авсан 6 зээлдэгч зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй, хугацаа хэтрүүлэн санд 35787.1 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоосон.

### **2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэй тооцох асуудал гараагүй.

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

### **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Гурванбулаг сумын Засаг даргын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 1599073.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1550070.4 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь 2018 онд тусгай зориулалтын шилжүүлгээр 1105705,7 санхүүгийн дэмжлэгээр 290562,9 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 60165,9 мянган төгрөгийн санхүүжилт авч орон нутгийн төсвөөс 62610,3 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 16200.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын болон орон нутгийн тусгай сангийн урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 176796,0 мянган төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг авч үзвэл орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 29350,0 мянган төгрөг ба гүйцэтгэлээр 38390,0 мянган төгрөгийн орлого төвлөрч 9040,0 мянган төгрөг буюу 130,8 хувиар давуулан биелүүлсэн байна. Үүнд хадгаламжийн хүүгийн орлого 11524,0 мянган төгрөг, Хүү, торгуулийн орлого 480,0 мянга, нохойны албан татвар 80,0 мянга, Улсын тэмдэгтийн хураамж 24,5 мянган төгрөгөөр давж, ИОТХуудсаар орсон орлого 3240,2 мянган тасарсан байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Гурванбулаг сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 төрлийн зөвлөмж өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 42,9 хувь буюу 38089,7 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 16.8 хувь буюу 14970,0 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлж, 40,3 хувь буюу 35787,1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

№	Байгууллагын ангилал	Мянган төгрөг							
		Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-
2	ТШЗ	2	50757,1	2	38089,7	4	88846,8	2	88846,8
	Дүн	2	50757,1	2	38089,7	4	88846,8	2	88846,8

### Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил	Мянган төгрөг										
			Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
2	ТШЗ	2	50757,1	1	35787,1	-	-	1	14970,0	-	-	-	
	Дүн	2	50757,1	1	35787,1	-	-	1	14970,0	-	-	-	

### 2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)				Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
1	ТШЗ	5	-	-	-	5
	Дүн	5	-	-	-	5

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>348632644.26</u></b>	<b><u>416546704.96</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	26316865.17	53782411.05
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	26316865.17	53782411.05
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	26316865.17	53782411.05
31211	Төрийн сангийн харилцах	26316865.17	53782411.05
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	172723299.28	188424901.39
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4062559.50	2526373.61
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	5353933.24	27353933.24
3351	Байгууллагаас авах авлага	5353933.24	5353933.24
3352	Хувь хүмүүсээс авах авлага		22000000.00
<b>336</b>	<b>Зээлийн авлага</b>	163306806.54	158544594.54
<b>3361</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	163306806.54	158544594.54
33612	Хувь хүмүүст олгосон зээл	163306806.54	158544594.54
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	149592479.81	174339392.52
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	34644402.78	45212990.86
35110	Тусгай зориулалттай материал	34644402.78	45212990.86
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	97658077.03	110801401.66
35410	Бичиг хэргийн материал	8049389.00	7340645.00
35420	Аж ахуйн материал	84178351.51	98102326.51
35440	Түлш, шатах тослох материал	3183788.50	3002509.15
35450	Барилгын засварын материал	1636300.00	1252000.00
35460	Хүнсний материал	610248.02	1103921.00
35600	Мал амьтад	17290000.00	18325000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3650652724.26</u></b>	<b><u>3682375152.05</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3650652724.26	3682375152.05
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3650198557.51	3613848985.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	4242249876.00	3435176949.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1024439649.97	-279295920.38
39203	Авто-тээврийн хэрэгсэл	168983136.00	249117936.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-129908495.35	-140020528.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	457492793.95	494330852.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	-315626326.44	-383499925.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	231654427.60	244254928.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	-119167184.20	-146966318.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	170357492.00	190389992.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-67703402.46	-87434771.52
39216	Дуусаагүй барилга, байгууламж	20000000.00	20000000.00
39217	Ном	16305890.38	17795790.38
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	454166.75	68526166.95
39301	Програм хангамж	3195000.00	3195000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2740833.25	-2910833.05
39303	Бусад биет бус хөрөнгө		68242000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3999285368.52</u></b>	<b><u>4098921857.01</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>4525775.00</u></b>	<b><u>4858179.54</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	4525775.00	4858179.54
<b>413</b>	<b>Өглөг</b>	4525775.00	4858179.54
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	124500.00	3527518.10
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	246310.00	

Гурванбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	4154965.00	1330661.44
41361	Байгууллагад төлөх өглөг	3986965.00	1128011.44
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	168000.00	202650.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3994759593.52</b>	<b>4094063677.47</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3994759593.52	4094063677.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1784290325.57	1852532325.57
51101	Өмч: - төрийн	1784290325.57	1852532325.57
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1671714604.65	1564854831.69
51210	Өмнөх үеийн үр дүн	1568771511.88	1671714604.65
51220	Тайлант үеийн үр дүн	102943092.77	-106859772.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	538754663.30	676676520.21
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3999285368.52</b>	<b>4098921857.01</b>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2129682039.59</b>	<b>1802286968.36</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>13977687.00</b>	<b>33885995.50</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	8542227.00	7759845.50
<b>1102</b>	<b>Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч</b>	8542227.00	7759845.50
110201	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	8542227.00	7759845.50
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	4041400.00	3971630.00
113002	Бууны албан татвар	4041400.00	3971630.00
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	1394060.00	22154520.00
<b>1180</b>	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	1094060.00	874520.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1055060.00	874520.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	39000.00	
<b>1182</b>	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	0.00	20900000.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр		20900000.00
